

Хидан Чобо

# МОГОЛ

*нутгаар*



**АЯН ЗАМЫН**

*тэмдэглэл*



Хидан Чобо

МОНГОЛ

*нутгаар*



*Аян замын тэмдэглэл*

Улаанбаатар хот  
2023 он.





ННА 63  
ДАА 900

Хидан Чобо

МОНГОЛ  
*нутгаар*

*Аян замын тэмдэглэл*

*Унгар хэлнээс монгол хэлнээ хөрвүүлсэн: Гурдагвын Энхтөр*

*Хянан тохиолдуулсан: Гэндэнжамцын Хишигбадам*

*Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Туулсүрэнгийн Бат*

“Хүслийн өнгө” ХХК-д хэвлэв.

ISBN 978-9919-9372-8-7



## ӨМНӨТГӨЛ

Хидан Чобо нь 2021, 2022 онуудад Монгол Улсад хээрийн судалгаа хийсэн, Евро-Азийн тал хээрийн бүсийг судалдаг Унгарын шилдэг мэргэжилтэн, түүхч-археологич, их сургуулийн багш хүн юм. Тэрээр Унгар-Монголын археологийн салбарын хамтын ажиллагааны хүрээн дэх Ар Гүнтийн малтлагад оролцож, олдворыг тодорхойлох тал дээр Монголын археологичдод үнэтэй зөвлөгөө өгч ажилласан. Энэхүү ажлынхаа үр дүнд тэрээр Унгар, Монголын ёс заншил, археологийн олдворуудын ижил төстэй талууд мөн Монгол нутагт амьдарч байсан нүүдэлчин ард түмний үлдээсэн хот, хотын туурь, булш бунхныг танилцуулсан эрдэм шинжилгээний, уншихад сонирхолтой аялын тэмдэглэлээ бичжээ.

Хидан Чобо хээрийн судалгааныхаа үеэр өнөөгийн Монгол болон Унгар улсын нутаг дэвсгэрт асар том гүрэн байгуулсан Хүннү нарын тухай тусад нь судалсан байна. Мөн Хэрлэн голын дагуу орших хүннүгийн төмөр хайлуулах зуухны суурин газрын туурийг өөрийн биеэр очиж үзсэнээр хүннүчүүдийн дунд төмөр боловсруулах үйлдвэрлэл өндөр хөгжсөн байсан гэдэгт тэрээр бат итгэлтэй болсон. Мөн тал хээрийн эзэнт гүрнүүдийн төв болох Орхоны хөндий болон Монгол улсын бусад бүс нутгуудаар аялж, археологийн ямар олдворууд, үнэт дурсгалууд хадгалагдаж байгааг судалжээ.

Энэхүү номноос бид тал хээрийн нүүдэлчдийн зэвсгийн талаар сонирхолтой чухал мэдээллүүдийг олж авах боломжтой. Хидан Чобо нь Унгар улсын энэ чиглэлийн хамгийн шилдэг мэргэжилтнүүдийн нэг юм.

Унгарын өмнөх аялагч, судлаачидтай харьцуулахад Хидан Чобо Монголд анх ирэхэд эх орондоо ирсэн мэт сэтгэгдэл төржээ. Түүний хувьд Монгол орон харийн биш байсан бөгөөд



монголчуудын уламжлалд унгарын уламжлалтай ижил төстэй олон зүйл байгааг ч олж илрүүлжээ.

Энэхүү сонирхолтой номыг уншихыг та бүхэнд санал болгож байна. Мөн энэ сэдэв Монголын шинжлэх ухааны судлаачдын сонирхлыг татаж, хамтарсан судалгааны төслүүд удахгүй хэрэгжинэ гэдэгт итгэж байна.

Др.Обрущанский Борбала Анна

Түүхч-дорно дахины судлаач,  
Унгар Улсаас Монголд Улсад суугаа Онц бөгөөд  
Бүрэн эрхт Элчин сайд



## МОНГОЛ НУТГААР

Би хүүхэд байхдаа Монгол орны тухай, монголчуудын талаар ихийг сонсож, уншсан юм. Тэр үед Эрдий<sup>1</sup> нутгийн унгар хүн миний хувьд Монгол орон хүрэх боломжгүй алс холын гайхамшигт ертөнц байсан бөгөөд 1989 оноос өмнө тийшээ очих боломж хомс байсан. Түүнээс хойш олон жилийн дараа Унгар судлалын хүрээлэнгийн археологичийн хувьд Монгол оронд хэд хэдэн удаа очсон. Ямар нэгэн учир шалтгаанаас ч юм уу (энэ бүгдийг Шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбарлаж томъёолох боломжгүй) яагаад ч юм анх Монголд очиход эх орондоо очсон юм шиг мэдрэмж надад төрсөн. Яг л Колужварын ойролцоох нүцгэн тал, өвслөг, хөндий толгод, Микеши байшингууд эсвэл Дымешт очсон мэт.

Жижиг нуур цөөрөм, гол горхи, өнчин хуш эсвэл хус моднууд болон бэлчээрлэж буй малын үнэр нь нэг л танил дотно. Тал нутгийн нумын хөвч татагч ард түмний хамгийн баруун захын нутаг нь Карпатын сав газар байсан бол зүүн зах нь өнөөгийн Монголчуудын амьдарч буй нутаг бөгөөд нийт нутгийн хэмжээ Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаагүй том газар нутаг байсан нь тохиолдлын зүйл биш юм. Унгар, монгол хоёр ард түмний түүхэнд ч тэр, өнөөдөр ч гэсэн тэдний нэг хэсэг нь (хэдэн саяар тоологдох) эх орондоо бус өөр газар амьдарч байгаагаараа адил төстэй юм. Хоёр улс “өөртэйгөө л хиллэдэг”. Монголчууд ч гэсэн унгарчуудын нэгэн адил XX зууны эхэнд өөрсдийн “трианон”<sup>2</sup>-ын зовлонг амссан. Тулааны талбарт хүчирхэг, догшин, эрэмгий зоригтой байдаг Унгар, Монголын ард түмэн харин энхийн цагт хүлээцтэй бас тэвчээртэй. Хоёр улсын аль аль

- 1 Дэлхийн 1-р дайнаас өмнө Унгар улсын нутаг байсан одоо Румыны баруун хэсэгт байдаг унгар үндэстнүүд амьдардаг нутаг.
- 2 Дэлхийн 1-р дайны дараа дайнд ялагч том гүрнүүд “трианон”-ын гэрээгээр Унгар хаант улсын нутаг дэвсгэрийг хуваасан



нь хүчирхэг гүрэн байхад хүн болгон өөрсдийн шашнаа чөлөөтэй шүтэж, төрөлх хэлээрээ ярьж, гарал үүсэл харгалзахгүйгээр төрийн өндөр албан тушаал хашиж байсан. Шашныг чөлөөтэй шүтэх талаар Эрдийд 1568 онд хуульчилсан бол Чингис хаан аливаа шашныг хавчин гадуурхахыг хориглож, Хубилай хаан төрөл бүрийн шашны томоохон баяруудад өөрийн биеэр оролцон хүндэтгэл үзүүлдэг байсан.

Монголыг зорьсон анхны аяллын үеэр гурван зүйл миний сэтгэлд хүчтэй нөлөөлсөн. Эхнийх нь орон зай байсан. Энд би юуны түрүүнд урт хол нислэгийн тухай биш харин Монгол улс доторх орон зайг хэлж байгаа юм. Зөвхөн Алтайн нуруу л гэхэд 1200 гаруй км урт бөгөөд өнөөгийн Монголын газар нутаг Унгарын газар нутгаас 16 дахин том юм. Нэг суурингаас нөгөө суурин руу, эсвэл археологийн нэг дурсгалт газраас нөгөөг хүртэл хэдэн цагаар тэр ч бүү хэд хоногоор ч явна. Уулс болон толгодуудыг ороосон шороон замуудаас үүдэн суурингуудын хоорондох зай их юм шиг санагдсан байж магадгүй юм.

Хоёр дахь нь жинхэнэ тал хээр нутаг. Хэдэн зуун километр үргэлжлэх хээр тал байх ч ой, бут, сөөг торлог бүхий усархаг газар нутгийн хойд хэсэгт багахан хэмжээтэй байдаг. Энэ тухай тоба үндэстний (дундад зууны үед энд амьдарч байсан нүүдэлчин угсаатны бүлэг) нэгэн дуунд өгүүлдэг:

“Дугариг хэлбэртэй тэнгэрийн хаяа  
Дөрвөн зовхисыг бүрхэж  
Хязгааргүй цэнхэртэн цэлийнэ.”

Сэтгэлд тод үлдсэн гурав дахь зүйл бол Монголын агаар. Бид Чингис хааны төрсөн нутагт Хэрлэн голын хөвөөнд очсон. Орой болж умард зүгээс Сибирийн салхи үлээж байв. Хуш мод болон цэцэгсийн анхилам үнэртэй тэр салхи миний хувьд тансаг цэцэгсийн ханд мэт санагдсан. Бид Хүннү (азийн Хүннү)-гийн Их хааны умард зүгт орших ордны туурин дээр зогсож байсан. Тэрхүү салхи эрт цагт алсран одсон дэлхий ертөнцийн үнэрийг эргүүлэн авчирсан мэт... Рац Габор 1974 онд хэвлүүлсэн “Унгарчууд Монголд зочилсон нь” номондоо Монголын энэхүү өвөрмөц агаарын талаар өгүүлсэн байдаг.

Энэхүү гурван хүчин зүйлээс илүү чухал зүйл байсан нь монгол



хүмүүсийн надад, манай багийнханд болон унгарчуудад хандах ерөнхий хандлага байлаа. Монголын ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн захирал доктор Г.Эрэгзэн, кино найруулагч Банзрагчийн Баяр болон Улаанбаатар хотын барааны захын гадна таарсан халамцуу гурван согтуу эр, тэдний аль аль нь биднийг унгарчууд гэдгийг сонсоод чин сэтгэлээсээ баярлан “Монгол, Унгарын ард түмэн хоёулаа хүннүгийн удам, ахан дүүс” хэмээцгээж байв. Археогенетикийн судалгаагаар нотолсноор хоёр ард түмний дунд нийтлэг гени байдаг, үүнд азийн Хүннү нар “голлох үүрэг”-тэй гэдгийг зөвхөн Археологийн хүрээлэнгийн захирал л мэдэх боломжтой гэж бодсон юм. Судалгааны томилолтынхоо үеэр бид хэзээд туслахад бэлэн, нөхөрсөг хандлагыг байнга мэдэрч байлаа.

Хэрлэн голын нэгэн гарман дээр манай жийп машин суухад насанд хүрэгчид болон хүүхдүүд бүгд л бидний машиныг түрэлцэхээр яаран ирцгээсэн. Монгол хүмүүсийн хүлээх, амрах эсвэл өөр хоорондоо хууч хөөрөх, сэлгүүцэх нь мэдээж хэрэг зүүн Азийн бусад ард түмний л нэгэн адил.

Улаанбаатарт ч тэр, хөдөөд ч тэр хаана ч “сул чөлөөтэй сэлгүүцсэн” хүмүүсийг харж болно. Энэ талаар бодлогошрон суухуйд, Мориц Жигмондын хоньчдын тухай өгүүлсэн “Зэрлэг бүдүүлгүүд” хэмээх богино өгүүллэг миний толгойд орж ирсэн. Хоньчин Бодригийн эхнэр ч мөн адил хөл дээрээ явган суугаад “улаан хоньчин”-той хууч хөөрдөг. Энд хамгийн сонирхолтой нь, зохиолчийн эмээ нь тариачин биш протестант хамба ламын охин байсан ч “хоёр хөл дээрээ явган сууж байхдаа хамгийн сайхан амарч чаддаг байсан” нь бүр ч сонирхолтой. Бодит байдал дээр бидний эртний ёс заншил, итгэл үнэмшлийг малчид илүү их хадгалан үлдсэн байдаг. Магадгүй явган сууж хууч хөөрөх нь нэг мянган жилийн өмнөх үйл ч юм бил үү. Энэ бол огт санамсаргүй зүйл биш. Монголчууд үүнийг “явган суух” гэж нэрлэдэг.

Үүнээс гадна монголчууд “суудал”-ын уламжлалт хоёр хэлбэрийг ашигладаг. “Завилан суух” бол бидний нэрлэж сурснаар “Турк суулт” юм. “Өсгий дээрх суулт буюу өвдөглөж суух” гэдэг нь хоёр хөлийн ар тал нь нэг шугаманд байхыг хэлдэг. Японы тулааны урлагаар хичээллэгч хэн бүхэн энэ суултыг сайн мэддэг. Ингэж суухдаа ярилцагч руугаа хөлөө жийж суух нь тохиромжгүй юм. Ярилцаж байхдаа хоёр гараа сагалдаргалан толгойныхоо ард



авах нь зохисгүй юм. Бэлэг өгч, авахдаа заавал хоёр гардана. Мөн мэндлэхдээ хоёр гараа барилцах (гар барихдаа хамтрагчийнхаа баруун гарын шууг зүүн гараараа атгах) нь маш хүндтэй үйлдэл юм. Хоёр гардан авсан бэлгээ духан дээрээ хүргэх нь хүндэтгэлийн илэрхийлэл болно.

Монголчууд бэлэг өгч, авах дуртай. Бэлгийн хэмжээ, үнэ гэхээсээ илүү чин сэтгэлийг чухалчилдаг аж. Гэхдээ өөр итгэл үнэмшилтэй холбоотой агуулга бүхий зарим зүйлсийг бэлэглэдэггүй. Энэ бол цахиур чулуу юм. Цахиур чулуу нь эртний унгарчуудын дунд ид шидийн зүйл хэмээгддэг байсан. Манай эртний үлгэр домогт шулмасаас зугтсан залуу цахиур чулууг эргүүлэн шидэхүйд тэр нь тэнгэрт тулсан хад болон хувирсан хэмээн гардаг. Шулмас хадыг тойрч гарах хэрэгтэй болдог ч дараа нь залуугийн шидсэн алчуурнаас нуур үүсдэг, мөн түүний шидсэн эвэрт самнаас өтгөн ой ургадаг ингэснээр шулмас бүгдийг тойрох хэрэг гардаг. Эвэрт сам нь Түрэг, Кидан, Монголын үеийн булшнаас ихэвчлэн олддог. Хэлбэр нь ихэнхдээ Марош орчмын сууринд амьдарч байсан эмээгийн минь самтай төстэй бөгөөд тэр нь одоо ч надад байдаг. Магадгүй, би далд ухамсартаа самны ид шидийн чадварыг илүү мэдэрсэн юм болов уу?...

2022 оны 5-р сарын томилолтын зорилгуудын нэг нь, Архангай аймаг дахь Хүннүгийн булш болон суурингийн бэхлэлтийн туурийг судлах явдал байсан. Биднийг Улаанбаатараас хөдлөх үед баруун хойноос хүчтэй салхитай байсан ба цааш явах тусам улам ширүүсэв. Шөнөдөө хасах 6-8 хэм, өдөртөө нэмэх 8-10 хэм байсан. Туул гол, дараа нь Орхон гол дээрх нэгэн аюултай гэмээр модон гүүрээр гарахын өмнө жолооч маань машинаасаа бууж гүүрийг сайтар нягтлан шалгасан. Тэр өдөр бид ойролцоогоор 600-гаад км замын талыг асфальт болон шороон замаар, талыг нь хээрийн бүдэг жимийг даган туулсан. Замын хоёр талаар уулс, уулсын хөндийд мал сүрэг бэлчиж байсан. Морьтой болон мотоцикльтой малчид малаа бэлчээрлүүлэн хариулцгааж яваа нь харагдана. Дундаж хэмжээний тоотой малыг голдуу 2-3 морьтон эсвэл 2-3 мотоцикльтой хүн хариулна. Эгц өндөр уул толгодын бартааг үл хайхран малынхаа дунд сүлжин давхилдах тэднийг харсан ямар ч бартаат замын мотоциклын тамирчин атаархмаар. Автомашины жолооч нарын хувьд ч мөн адил үнэхээр чадварлаг гэж хэлж болно. Тэд өдөрт 700-800 км-ыг туулахдаа тал хээрийн



жимээр дов толгод, уулсын аль алинаар (миний хувьд бүгд адилхан) баримжаа аван ажрахгүй давхина.

МЭӨ I зуунд баригдсан Хүннүгийн эзэн хааны ордны тууринд судлах зүйл их бий. Дунд зэргийн хэмжээтэй хиймэл нуур руу баруун зүгт орших Төмөртийн уулнаас татсан ус дамжуулах чулуун сувгаар усыг татдаг байсан. Ийм учраас Хүннүчүүдэд Ром руу явж хиймэл нуур цөөрөм ус дамжуулах хоолой үзэх шаардлага байгаагүй. Прискос Реторын тэмдэглэснээр Зүүн Ромоос уран дархчуул, барилгачдыг авчирсан ч гэсэн Аттила хаанд Ромын загвар бүхий усан сангийн хэрэгцээ шаардлага байгаагүй. Төв Азийн Орхон голын хөвөөнд ордон барьсан Хүннүгийн их хаан, Ромын ус дамжуулах суваг, хиймэл нуур, усан санг үзсэн нь юу л бол. Монголын археологичид өнгөрсөн жилүүдэд Төмөртийн уулнаас төмөр хайлуулах, тоосго шатаах зуухыг олсон. Монгол археологичид 2021 оны зуны малтлагаараа Хэрлэн голын нэгэн тохой буюу Хэнтий нурууны хойд хэсэгт орших Хүннүгийн хааны ордны туурь орчмоос төмөр хайлуулж байсан хэд хэдэн газрыг илрүүлэн малтсан байна. Тэдгээр зуухны хийц нь Ромынхтой адил биш харин Төв Азиас Карпатын сав газар хүртэлх нүүдэлчдийн хэрэглэдэг байсан зуухтай адилхан байсан. Малтлагаар илэрсэн тэдгээр газрууд (керамик зуухууд)-ыг Монголын археологичид МЭӨ II-I зууных хэмээн үзэж байна.

Монголын Хүннүгийн булшнаас шавар эдлэл элбэг гарч ирдэг нь нүүдэлчид шавраар сав суулга хийж чаддаггүй байсан, харин тэд “Суурин соёл иргэншилт ард түмнээс авсан” гэсэн мэргэжлийн бус, үндсээрээ буруу үзлийг илт үгүйсгэж байна. Мөн элбэг идээ будааны тахилга нь Хүннүчүүд Готуудын илүүдэл хүнсийг байнга булаадаг, учир нь тэд юу ч ургуулдаггүй, зүгээр л эргэн тойрны ард түмнийг дээрэмддэг гэсэн “нийтийн дунд тархсан буруу ойлголт”-ыг няцааж байна. Бона Иштван “Хүннү нар ба тэдний их хаад” хэмээх номынхоо хоёр бүлгийг хүннүчүүдийн талаарх зохиомол буруу ойлголтыг арилгахад зориулсан. Хүннүгийн хааны ордны туурийг үзэсний дараа бид Ази дахь хүрэл зэвсгийн үеийн булш хиргисүүр болон Түрэгийн үеийн хүн чулууг үзсэн. Тэгээд гурван цаг орчим машинаар яваад (салхи улам ширүүсч, цаг агаар улам л сэрүүсч байсан) харанхуй болж байхад Архангай аймгийн Цэцэрлэг хотод зочид буудалд



ирсэн. Барилга нь социализмын үеийнх, тавилга нь хуучирсан ч оройн хоол нь найрсаг язгууртны зэрэгтэй хүлээн авалт байсан. Дөрөв таван төрлийн хоол мөн цай усыг тооцохгүйгээр дөрөв таван төрлийн уух зүйлс дэлгээстэй байсан. Эцэст нь жолооч нар маань идэж ууж болох цаг ирлээ. Яагаад гэвэл тэд бүхэл өдрийн турш зөвхөн цөцгийтэй, давстай, сүүтэй цай уусан бол бид арын суудал дээр бага багаар идэж байсан, бас заримдаа морин цэргийн заншлаар хэд хэдэн лааз шар айраг уусаар явсан. Оройн хоолны үеэр тэдний гүйцэтгэсэн хүнд хүчир ажлынх нь төлөө талархал илэрхийлсэн.

Маргааш өглөө нь зочид буудалдаа монгол, европ уламжлалт өглөөний цай уув.

Буддын шашны хийд байж байгаад музей болсон газрын захирлыг хүлээх зуураа тэндэхийн цайны-кофены газар руу орлоо. Ерээд оны их сургуулийн оюутны буфейны тохижилт, уур амьсгал биднийг угтсан. Яг ийм орчныг би өмнө нь Гүржид хэд хэдэн удаа мэдэрсэн. Энэ хоёр улсын орон сууцны хороолол дахь жижиг дэлгүүрүүд унгар дахь жижиг дэлгүүрүүдтэй төстэй. Гүржийн их сургуулийн оюутан охид ижил хувцсаар жигдэрдэг бол монголчууд тэгддэггүй. Монголд уламжлалт монгол хувцаснаас эхлээд орчин үеийн готын загвар хүртэл-Габорын хэлдгээр хагас вампир стилийн хувцаслалт бүгд байдаг ба монгол охид төрөл бүрийн загвараар чөлөөтэй хувцасладаг. Зарим талаараа ерээд оны “Барууны хэв маягыг хуулбарлах” үеийг санагдуулж байсан (зар сурталчилгаа, ханан дээр эрээчих, караоке...) ба тэр үеийн “хүүхдийн өвчин”-ийг монголчууд биднээс илүү богино хугацаанд туулан гарна хэмээн найдаж байна. Монголын “The Nu” хамтлагийн хэд хэдэн дуунд энэ тухай гардаг. Тэдгээрийн дотроос Юу вэ-Юу вэ! хэмээх дуу. Ийм зүйлсийг харахад XVIII зууны үеийн Унгарын нэрт зохиолчийн “Үндэстэн бүр өөрсдийн эх хэлээрээ л эрдмийн оргилд хүрдэг, хэзээ ч харь хэлээр биш!” гэсэн үг байнга л миний санаанд ордог. Цэцэрлэг хотын музейн захирлын байшингийн модон тааз нь Эрдийгийн протестант сүмүүдийнхтэй төстэй. Миклош бид хоёр голдуу Хүннүгийн модон авсны алтан чимэглэлтэй төстэй зургийг авсаар явсан (Бэлх, Гол-мод) Европт нүүж очсон Унгарчуудын хавтаган дээрээс яг тийм хээ бүхий (Уйфехерту - Мичкепуста) соёлын дурсгалыг харж болохоос гадна



XVIII-XIX зууны үеийн унгар үндэстний модон тавилга дээрээс сийлсэн, будсан байдлаар нь ч бас харж болно. Музейн агуулах нь судлаачдын хувьд эрдэнэсийн сан гэлтэй. Барилга байгууламж, хашаа нь бага зэрэг хуучирсан ч угтан авсан хүмүүсийн найрсаг нөхөрсөг харилцаа нь музейн сан хөмрөгийн нэгэн адил онцгой сэтгэгдэл төрүүлж байлаа. Их танхимд иж бүрэн тоноглолтой гэр, тэргэнд хөллөсөн чихмэл сарлаг байх ба дарханы болон мужааны багаж хэрэгсэл, төмөр хайлуулах зуух, хувцас хунар, ан агнуурын хэрэгсэл байх аж. Сүмийн барилга дотор археологийн болон шашны түүхийн үзмэрүүд байна. Хүннүгийн тогоо, шавар вааран эдлэл Миклошийн сонирхлыг ихэд татсан. Хүннүгийн суурьтай тогоонууд нь онцгой ач холбогдолтой юм. Яагаад гэвэл тогоонууд нь тэдэнд хамаарах онцгой олдворуудын нэг юм. Тэдгээр тогоонууд нь Хүннүгийн төр үүсэн байгуулагдсан нутаг (ерөнхийдөө өнөөгийн Монгол улсын нутаг) болон байлдан дагууллынхаа явцад хүрсэн газар (Троес буюу өнөөгийн Франц улсын нутаг) зэрэг хоёр захын цэгийг тодорхойлдог. Тэр цагаас хойш эртний үед ч, дундад зууны үед ч, орчин үед ч ямар ч цэрэг арми ийм хол замыг туулж чадаагүй. Хүннүчүүдийн цэрэг армийн хүчин чадал нь зөвхөн сайн зэр зэвсэг, өргөн уудам нутагт нөлөөлөх чадвартаа байгаагүй. Харин тагнан тандах нарийн арга болон хурдан маневарлах чадварт оршиж байсан. Бона Иштван профессор эртний Ромын зохиолчийн хүннүчүүдийн талаар хэлсэн үгийг иш татсан байдаг “... тэд хаана гарч ирдэг вэ гэвэл тэднийг огт гарч ирнэ гэж төсөөлөөгүй газар гарч ирдэг, тэдний хурд нь тэдний тухай цуу ярианаас ч хурдан байдаг. Энэ нь авар, унгар, хүннү болон монголын цэрэг армийн онцлох чанар юм.” Эдгээр нь олон мянган жилийн цэргийн уламжлал-байлдах урлагийг өвлөсөн маш нарийн инженерчлэлийн аргаар боловсруулсан цэрэг армийн шилжилт хөдөлгөөн байсан ба энэ тухай тэдэнтэй эн зэрэгцэн оршиж байсан Ром, барууны болон Византийн эх сурвалжуудаас бид мэдэж болно. Энд монгол зэр зэвсгээс гадна Хятад, Төвд, Дундад Ази болон орос маягийн илд болон сэлэм ч байна. Хоёр талтай хүрэл сүх ч сонирхол татна. 2021 оны намар Улаанбаатар дахь Археологийн хүрээлэнгийн сэргээн засварлах цехэд ийм давхар иртэй (хоёр талдаа иртэй) сүхнүүдийг үзсэн бөгөөд заримынх нь модон иш нь хүртэл байсан. Тал хээрийн онцгой нум сумнаас гадна сүх нь мөн олон мянган



жилийн түүхтэй бөгөөд морьтон нүүдэлчид ойрын зайн тулаандаа өөрийн гэсэн зэвсэгтэй байсан учир эдгээрийг Ромчуудаас эсвэл Византийнхнаас авах шаардлага байгаагүйг тодорхой харуулж байна. Сэлэм, муна, эмээл, дөрөө, төмөр болон хүрэл хуяг нь морьтон нүүдэлчдийн бүтээл юм.

Миний хувьд Цэцэрлэг дэх музейн хамгийн сонирхолтой зүйл бол гэрийн шүршүүр байв. Хаалганы яг баруун гар талд (гэр дотроос гадагш харахад) гал тогооны сандал хэлбэртэй тавиуртай угаалгын хэсэг, түүний баруун талд гэрийн хананд дүүжилсэн хоёр том арьсан уут байв. Дотор нь айрагны бүлүүр байгаагүй бөгөөд 150-160 см өндөрт дүүжилсэн байсан учир энэ бол айрагны хөхүүр биш юм. Хэрвээ арьсан уутыг хазайлгавал урагш бөхийсөн хүний хүзүү, дагз руу ус асгаж болохоор байсан. Үүнийг хармагц, Биборт төрсөн Константин хааны (913-959) зан үйлийн ном шууд санаанд орсон. Эзэн хааны хувьд дайнд явахад нь Унгарын язгууртнууд хуарандаа усанд орох боломжтой байсан. Эзэн хаан ийнхүү тэмдэглэсэн байдаг. Өндөрт өлгөсөн цорго бүхий арьсан уут байх ба энд аян замынхаа тоос шороог угааж болно. Эзэн хааны үзэж буйгаар үүнийг унгарчууд цорго-цэрга хэмээн нэрлэдэг байсан.

Морьт нүүдэлчдийн бас нэгэн гайхшруулсан зүйл бол Чинтолгойн ойролцоох Киданы бэхлэлтээс олдсон шүдний сойз байв. Монголын археологичдын илрүүлсэн өнөөгийн шүдний сойзтой төстэй хоёр модон шүдний сойз энэхүү жижиг музейн сан хөмрөгт хадгалагдаж байна. Сойзны нэг хэсгийг 6-6 нүх бүхий хоёр эгнээтэй амьтны үсээр хийсэн байна. Киданчууд 924 онд Киргизийн төрийг мөхөөж, удалгүй Зүүн хойд Хятадыг мөн эзлэн авсан. Монгол эсвэл монгол хэлтэй төстэй хэлээр ярьдаг Киданы эзэнт гүрнийг 1125 онд Зүрчидүүд мөхөөсөн. Тэдний нэгэн хатан хааны нэг сайхан шүлэг хятадаар орчуулагдсан нь хадгалагдан үлдсэн.

Миний овог Кидан (к, h үсэг заримдаа зэрэг бичигддэг, заримдаа к, заримдаа h үсэг) учраас монголчууд миний нэрийг их сонирхож байсан. Хариуд нь би Казакын нутагт Хидан нэртэй хүмүүсийг танина. Опустасерт болсон Кун-Кипчакийн бага хурал дээр тэдэнтэй тааралдсан хэмээн хэлтэл тэд, тэгвэл бид хамаатнууд юм байна хэмээн хошигноцгоож байсан. Миний



нум сум харвах, туялзуур сэлмээр тулалдах, морь унах дуртай байдгийг үүнтэй холбон “тайлбарлаж” болох юм.

Оросын археологич Михаил Горелик “Монгол-Татарын арми” номондоо Киданчуудын зэвсэг, байлдааны арга барилын талаар дурдсан байдаг. Төв Азид Киданчууд хамгийн түрүүнд сэлэм хэрэглэсэн байдаг.

Цэцэрлэг дэх музейн агуулахад уран дарханы мужааны арьсан багажны багцыг харж болно. Тэд бүгд монголчуудын өөрсдийн хийцнийх тул Визант болон Каролиний багаж хэрэгслийг хуулбарлах, хэрэглэх шаардлагагүй байж. Тэгэхээр өмнөх “онол”-ыг залруулж, өөрийн түүх, газарзүйн орчинд нь бодитойгоор дүн шинжилгээ хийх цаг болсон байх.

Лийр алимтай хичнээн төстэй ч алимнаас амтлаг биш байдаггүйтэй адил Скандинавын модон барилга нь Византийн эсвэл Италийн барилгатай хичнээн төстэй байснаас үл хамааран сайн эсвэл муу байдаггүй. Бодит байдал дээр харилцан уялдаатай ч нэг нь нэгнээсээ үл хамааралтай байдаг. Нэг талыг барьсан харилцаа нь санал солилцох боломжгүй дарангуйллын үед төрийн болон аж ахуйн нэгжийн хэмжээнд байдаг.

Өнөө цагт бид иймэрхүү зүйлийг голчлон нийгмийн сүлжээ, мэдээллийн сайтуудаас хардаг. Тэд давхар стандарт хэрэглэдэг, энэ нь ихэнхдээ ерөөсгөл байдаг бөгөөд тэдгээр хаягуудын нэр үнэн эсэх эсвэл нууц нэрийн ард хэн байгааг бид мэдэхгүй... Эдгээрийн цаана ямар зорилго агуулагддагийг олон хүн мэднэ дээ.

Музейгаас гараад бид Цэцэрлэг хотын ойролцоох саяхан олдсон Хүннүгийн булш руу хөдлөв. Цаашдаа үүнийг Монголын археологичидтой хамтран судлах болно. Замын хоёр талаар уулс, хад асга, хэсэг хуш модод жирэлзэн өнгөрнө, харин шороон зам байхгүй юм. Туулах чадвар сайтай машинаас гадна мориор, тэмээгээр эсвэл дөрвөн дугуйт мотоциклоор л ийшээ хүрч болно. Цэцэрлэг хотоос нэг биш, тав зургаан цаг явах байсан ч хамаагүй ийшээ мориор л ирмээр... Энэ хоёр хоногийн хугацаанд жихүүн салхи, жавартай хүйтнийг би ер анзаарахаа больсон байсан. Дугариг хэлбэртэй, таруу байрласан чулуунуудаас булшны байршил тодорхой харагдана. Тухайн газрын судалгааг Б.Баярын хийсэн дроны бичлэг маш гайхалтайгаар баяжуулсан.



Археологич, профессор Эрдий Иштваны (тэрээр миний багш байсан бөгөөд маш их мэдлэг олгосонд нь өнөөдрийг хүртэл түүнд талархаж явдаг) үед судалгаанд асар хэрэгтэй дроны бичлэг хийдэггүй байсан нь харамсалтай.

Монголын археологийн түүхэнд анхдагч байсан тэдний хувьд дурсгалт газруудад очиход мэдээж хэцүү байсан байх. Гэхдээ одоо ч тэдний мэдлэг, туршлага археологичдод зайлшгүй хэрэгтэй хэвээр байна.

Хүннүгийн булшнууд нь ихэвчлэн гурван талаараа хадтай, эгц толгодоор хүрээлэгдсэн тэгш өндөрлөгт байрладаг ба урд, баруун урд тал нь онгорхой. Урьдчилсан тооцооллоор, энэ оршуулгын газарт зуу гаруй булш байх магадлалтай. Хэдийгээр хад асганы өнгө нь улаан хүрэн ч гэсэн энэ газар бүхэлдээ Эрдийгийн Тордагийн ойролцоох Туригийн хавцлыг санагдуулж байсан. Уур амьсгал нь ч ижилхэн мэт. 1912 онд Туригийн хавцалд Дохуйн хаданд ирийг нь дээш харуулан “чулуун завсар хавчуулсан” (хадны хагаралд) илд олдсон. Ойролцоо нь Скифийн оршуулга байсан ба Тордагийн Турийн үлгэрт агуйн тухай өгүүлдэг. Унгар, Монголын үлгэрт хэд хэдэн, маш нарийн ижил төстэй зүйл байдаг. Аль алинд нь хурмастын охин хайртай залуудаа морь бэлэглэдэг, харин морь үхсэнээр тэд харилцах боломжгүй болж, үлгэр гунигтайгаар төгсдөг. Гэхдээ Унгарын түүхэнд Фиртош дагинын шилтгээний туурийн дэргэдэх хадан баганыг нартай эсвэл үүлэрхэг бороотой гэх мэтээр цаг агаарыг заагч чулуу хэмээдэг. Бирталон Агнешийн судалгаанаас харахад, монголчууд мөн адил “цаг агаарыг тодорхойлогч чулуу”-тай байсан. Скифийн заншлаар илдийг газарт эсвэл хадны ангалд ирийг нь дээш харуулан хавчуулдаг байсан. Геродот скифчүүдийн илдний зан үйлийг олонд таниулсан. Тордагийн Турийн ойролцоогоос Скифийн оршуулга олдсон нь тохиолдлын хэрэг биш юм. Тосгоныхоо газар нутгийг оршин суугчид нь дараах байдлаар нэрлэжээ: Улсын зам, Тосгоны зам, Их зам, Досуй болон Сития. Хүннүгийн булшны хадны зүүн хойд хэсэгт суварга бий. Энэ нь хэдийгээр Буддын шашны уламжлалтай холбоотой ч Христээс өмнө амьдарч байсан Хүннү нар ч, өнөөгийн Монголчууд ч энэ газар ариун дагшин оршдог гэдгийг мэддэг байж.

Замд гарахаасаа өмнө сэлмээ сугалан, нарны мөргөл хийлээ.



Бараг хагас өдрийн турш баруун урд зүг рүү давхисаар үдийн хойно Уйгарын Орду Балик буюу одоогийн Хар балгас, хуучин Монголын нийслэл Хархорум хотод ирэв. Тэр хүртэл олон цагийг машинаар туулсан. Хоёр талдаа голдуу нүцгэн уулс дүнхийж, тавдугаар сар хэдийнэ гарсан ч алсад цасанд дарагдсан оргилууд цайран харагдана. Өндөр хавцлыг давахуйд цаана нь асар уудам тэгш өндөрлөгүүд, эцэс төгсгөлгүй цэнхэртэх тэнгэр бидний дээрээс нөмрөх мэт. Мориц Жигмондын нэгэн өгүүллэг санаанд минь орж ирнэ: нэгэн явган эмэгтэй зөвхөн “яван явсаар их тал руу ороод төөрчихсөн. Тэгээд тэр асар уудам, аймшигтай тэнгэрийн дор үхсэн.”

Ийм өргөн уудам, эцэс төгсгөлгүй хөхрөн цэлийх газар дээр хүмүүн хэмээгч нь өөрийгөө өчүүхэн гэдгийг мэдрэх нь гарцаагүй.

Уйгарын нийслэл Орду Балик нь Торгоны замын дагуух асар том өндөрлөгийн дунд оршдог. Өнөөдөр бидний харж буй асар том хэрэм (зөвхөн балгас) болон 12 метрийн өндөр бэхлэлт, цайз нь нийслэл хотдоо зориулагдсан бүтээн байгуулалт байжээ гэдгийг гэрчилж байна. Хэрмээр хүрээлэгдсэн энэхүү хотод ордон, сүм, дарханы газар дэлгүүрүүд байсан. Харин гадна талд нь үзэсгэлэнт цэцэрлэг, тариан талбайнууд байсан. Уйгаруудын дунд бөө шүтлэгтнүүд байсан бөгөөд тэд гэрэл ба харанхуйн тулааны тухай Манигийн сургаалийг дагаж мөрддөг байжээ. Түүнчлэн несториан христийн шашинтнууд болон буддын шашинтнууд ч тэнд байсан. Өнөөгийн Шинжаан мужид (Хятад) амьдарч буй Уйгарчуудын дунд лалын шашинтнууд олон байдаг.

Дундад зууны үед тэд бичиг үсэгтэй байсан бөгөөд өндөр соёл иргэншил бүхий эзэнт гүрнийг байгуулжээ. Чингис хааны “бичиг хэргийг” уйгарууд хөтөлж байсан бол монголчууд 1964 он хүртэл кирилл бичигтэй болох хүртлээ уйгар гаралтай бичгийг хэрэглэж байсан.

Нэгэн цагт уйгаруудын цэргийн хүч асар их байсан нь Хятадуудыг худалдаа хийхэд хүргэсэн бөгөөд Бөгү хаан (759-799) өөрийн биеэр цэргээ удирдан Хятад руу явж бослого даралцаж байжээ.

Энэ тухай Хятадын яруу найрагч Ту Фү шүлэгтээ дурдсан байдаг:



“Уйгарын жанжид энд байсаар байна.  
тэд гэртээ харьдаггүй, тэд шан харамж нэхсээр.

Ташуур дахин задрах вий,

Хятад хүрмийг дахин цусаар будах вий. (Латор Ласлогийн орчуулга)

Уйгарын хуягласан морьтнууд, нум сум, урт илд, тугтай жад агссан цэргүүдийг Кизил, Куча, Майя агуйн зургуудаас харж болно.

Хотын тууриас нэхмэл эдлэлийн үлдэгдэл, хэд хэдэн шавар тоосго, дээврийн шавар хавтан зэргийг олсон. Эдгээрээс тухайн үеийн гар урлалын хэв маяг, утас, тэр бүү хэл нэхмэлийн үйлдвэрлэлийн чанар, төрлийг ч дүгнэн харж болно. Хотын жинхэнэ гайхалтай хэсэг бол хуучин цайз-түүний орой хэсэг юм. Орой дээр нь өнгө өнгийн туг бүхий овоо бий. Хамгийн том нь Монгол төрийн далбаа. Габор бид нар хүндэтгэл үзүүлэн Унгарын далбааг тэнд мандуулсан. Тэнд байсан Монголчууд, Унгарчууд бүгдээрээ бидний энэ үйлдлийг дэмжиж байсан...

Дараа нь дахин толгод, уулс бас машины дугуйны мөрөөр гарсан замууд. Хоорондох зай их урт бөгөөд түүний дээрээс хязгаар нь үл харагдах хөх тэнгэр бүрхэн нөмөрнө.

Жийпний арын суудалд өдөр болгон өөр өөр хүн сууна. Учир нь холын замд явахад арын суудал нэлээд тух муутай байсан. Энэ тухгүй байдлыг Миклош Алтай эсвэл Чингис хаан шар айргаар тодорхой хэмжээгээр намжааж байсан бол олон цаг үргэлжлэх аяллын дараа бид ч хэдэн балга шар айраг эсвэл монгол сүүтэй цай уухад сайхан байдаг болсон.

Дундад зууны үеийн Монголын нийслэл Хархорумд бид үдийн хойно ирсэн. Тэндхийн музей нь дундад зууны үеийн монголчуудын амьдралыг хамгийн орчин үеийн “интерактив” технологи, гайхалтай эд өлгийн зүйлсээр дэлгэн танилцуулсан байсан. Миний хувьд, монгол үзмэрүүдээс хамгийн сонирхолтой нь дуут сумны зэв, хурц ирмэгтэй зэв, аварчуудынхтай төстэй монгол жадны толгой хэсэг байсан. Тэнд буй түр үзэсгэлэнд Баяннуурын Түрэгийн булш бүхий танхимыг нээсэн байв. Танхим руу хөтлөх коридорт дайчдын дүрс бүхий ханын зургууд байсан. Язгууртны алтан хайлш, морины хэрэгсэл нь аварчуудынхтай



төстэй. Энэ бүхэн санамсаргүй зүйл биш бөгөөд Түрэгүүд 552 онд Төв Ази дахь Аваруудын ноёрхлыг түлхэн унагаад, замдаа цагаан хүннүчүүдийг өөртөө нэгтгэн 567-803 (828) оны хооронд Карпатын сав газарт Аварын хаант улсыг байгуулсан юм. Тиймээс хүннүчүүд Карпатын сав газарт хоёр дахь удаагаа агуу их гүрний нэг хэсэг болжээ. Хуягласан морьд (унаачгүй), урт илдээр зэвсэглэсэн бие хамгаалагчдыг дүрсэлсэн шавар баримлууд маш сонирхолтой байсан. Эрдий Иштваны Аваруудын дорно дахины харилцааны тухай бичсэн номонд энэ тухай тэмдэглэсэн байдаг.

Булш бүхий танхим руу хөтлөх хонгил дахь дайчдын зураг нь (Монгол археологичид үүнийг 6-8-р зуунд хамааруулдаг) цэргийн хувцас хэрэглэл, зэр зэвсгийн түүхийн үүднээс ихээхэн ач холбогдолтой юм. Орой нь Монгол, Японы археологичидтой хүндэтгэлийн зоог барив. Азаар надад Сикэй нутгийн жимсний архи (палинка) байсан ба зочны ёсоор оройн хоолонд түүнийгээ нэмэрлэсэн нь япон археологичдын өмнө “нүүр тахалсан”. Уур амьсгал маш сайхан байсан. Зоогийн газарт хэсэг оросууд мөн оройн зоог барьж байв. Туулах чадвар сайтай жийп машинуудын чадлыг турших мэт зам харгуй нь бүүр Сибирийн чанад руу хөтөлнө. Тэдэнтэй хэдэн үг солилцохуйд тэд хатуу ширүүн, шийдэмгий хүмүүс шиг санагдсан. Хэзээ нэгэн цагт ийм аялалд оролцвол сонирхолтой байх...

Бидний хоноглох жижигхэн зочид буудал маань будагны үнэртэй, шинэхэн байр байлаа. Ариун цэврийн өрөөнд толь байгаагүй тул тэднээс толь өгөхийг гуйсан. Мөн тэнд шинэхэн будаг, хуванцарын үнэрийг дарахын тулд хүж асаасан байлаа. Жижиг буудал маань орчин үеийнх бөгөөд тэрхүү сууринд түүнтэй төстэй хэд хэдэн шинэ барилга баригдаж байсан. Хэрвээ хүсвэл гэрт хоноглож болох ба харин шүршүүр болон гар нүүрийн угаалтуур нь тусдаа байшинд байдаг. Гол хэсэгт нь байх том өргөө бол зоогийн газар юм. Ийм гэр-зочид буудлыг бид Монголд хэд хэдэн газарт харсан. Эдгээр нь эргэн тойрондоо цэвэр цэмцгэр, зохих хэмжээний барилга байгууламжтай байдаг. Эдгээр барилгууд нь үндэсний хувцасны нэгэн адил соёл уламжлалаа хадгалан аялал жуулчлалд хувь нэмрээ оруулж буй нь сайшаалтай юм.

Манай буудлын өмнө замын ажил явж байсан. Харин эсрэг талд орон нутгийн гал унтраах ангийн сургуулилтын талбай харагдана.



Дундад зууны үеийн Монголын нийслэлийг аялал жуулчлалын чухал төвүүдийн нэг болгохыг зорьж байгаа нь ажиглагдаж байлаа. Дундад зууны үеийн Унгарын нийслэл, хаадын бунхан бүхий Секешфехервар хот ч бас үндэсний өв соёлын төвүүдийн нэг болчихвол сайхан л байна. Унгар судлалын хүрээлэн Арпадын үеийн түр үзэсгэлэнг Секешфехервар хотод гаргасан нь ч тохиолдлын хэрэг биш юм. Тэр нь дэлхийн Унгарчуудын хувьд цаг хугацаа, байрлалын хувьд зүг чигээ олох мэдээллийн төв болох боломжтой юм.

Өглөөний цайны дараах бидний эхний аялал бол Эрдэнэзуу хийд. Тус хийдийг 1586 онд Автай сайн хан бариулж эхлүүлсэн. 1760-1796 оны хооронд анх баригдсан модон барилгуудыг чулуу болон плитагаар шинэчилсэн. XVI зууны сүүл үеийн эх сурвалжуудад тэмдэглэсэнээр нэгэн монгол барилгачныг Манзушир, мөн XVIII зуунд энд буй барималуудын нэг хэсгийг бүтээсэн уран барималчийг Очир Дарь бурхан хэмээн өргөмжилсөн байдаг. Барилгын нэг хэсэг нь хятад загвартай боловч Амдогийн алдарт Блабранг хийдийн нэрээр нэрлэгдсэн Лабран дугана нь Төвдөөс санаа авсан хэдий ч монгол онцлогийг өөртөө шингээсэн байдаг. Энэ бол өнөө үед үлдсэн ийм төрлийн бараг цорын ганц барилга...

Тус хийд нь гурван сүмийн барилга мөн хэд хэдэн жижиг барилгатай. Гол сүмийн өмнө Буддын шашны хамгаалагч хоёр бурханы хөшөө байрладаг. Нэг нь сүрдэм Лхам бурхан, нөгөө нь Төв Азийн нүүдэлчдийн хүсэмжит голомтыг “авран хамгаалагч”-дын нэг болох Гомбогүр сахиус юм. Голын сүмийн эхний давхарт жижиг дугана байх ба уул, хөндийг дүрсэлсэн ширээн дээр олон жижиг алтадсан бурхан өрөөстэй. Сүмийг эргэн тойрон харвах зориулалттай мэт нарийхан цонхтой дугуй хонгил байх. Энэ бол хийдийн хамгаалалтын систем бүхий хуучны цамхаг юм. Хийдийн гадуур нүүдэлчдийн онцлогийг илтгэн харуулсан хамгаалалтын мэт хана байна. 20-25 см-ийн голчтой, 5-6 метр урт саваагаар тодорхой зайд X хэлбэрийн нүхийг ухсан байдаг. Жад эсвэл жадны хэмжээтэй урт үзүүртэй гадаснуудыг түүнд зоодог байсан. Мод нь 70-90 см өндөр. Үзүүр нь дээшээ X хэлбэртэй жад мэт гадаснууд нь эрт цагт морьтон нүүдэлчдийн цэргийн хүрээг гэнэтийн довтолгооноос хамгаалдаг байсан. Эрт цагт ийм



модон жад, гадсыг хооронд нь холбон цэргийн хуаранг тойруулан байрлуулдаг байсан. Баруунд байдаг “Испани төмөр”-тэй төстэй санагдсан. Монгол дахь сүм дуганууд нь Сикэй нутгийн цайзат сүмүүдийн нэгэн адил дайн дажны үед тухайн нутгийн хүмүүс хоргодож болох бэхлэлт байсан. Сикэй нутгийн цайзат сүмүүдэд хамгаалалтын давхрыг тойруулан харвахад зориулсан жижиг цонхнууд мөн байдаг. Энд ч тэр, тэнд ч тэр сүмийн давхрууд нь хамгаалалтын системийн хамгийн эцсийн орогнох хэсэг байсан. Гадуураа бэхлэлттэй энэхүү сүмүүд болон ханаар хүрээлэгдсэн хийдүүд нь бүслэлтийг няцаахын тулд бус харин гадны гэнэтийн довтолгооноос ард иргэдийн амийг хамгаалах зорилгоор баригдсан байна.

Гадна талын цамхаг болон сүмийн барилгын дээвэр хоёулаа ногоон, шатаасан плитагаар чимэглэгджээ. Эдгээр хавтангууд дээр амьтад болон хүний нүүр царайг дүрсэлсэн бөгөөд дээврийн тахир төгсгөл нь амьтны хэлбэртэй байдаг. Плитан дээрх луугийн толгойн цоорхой нь мөн хошууны үүрэг гүйцэтгэдэг. Дээврийн орой дээр алтадсан суварга байна. Нарны гэрэлд алтадсан суварга, өнгөлөг дээвэр нь гайхалтай харагднам. Зүүн талын дуганд сүмийн тугнуудын хажууд Киданы үеийн цэргийн тугийг санагдуулам тугнууд байна. Эдгээр тугнууд дээр гриффин-индаш авааруудын (Карпатын сав газар дахь Унгарчуудын байлдан дагуулалтын давхар онолын дагуу Унгарчуудын 710-720 оны анхны давалгаа) бүснүүд дээрхтэй адил бэлгэдэл дүрс бий.

Хархорум хотын музейд буй Түрэгийн үеийн алтадсан бүсэн дээрх хээг Алмош, Арпадын үеийн хүмүүсийн эдлэл, хэрэгслүүд дээрээс ч харж болно. Эдгээр хээ угалз нь ихэвчлэн барилга байгууламжийн таазан дээр гарч ирдэг. Энэхүү ижил төстэй адилхан давтамж, тохиолдол нь “санамсаргүй зүйл” биш бизээ. Хүннү, Авар, Түрэг, Унгар үндэстний хувьд ижилсэл байхгүй юмаа гэхэд залгамж чанар бий. Багануудыг тойрон ороосон сүрлэг том, олон өнгийн, ам нь ангайсан луунууд нь сүрдмээр бөгөөд гайхалтай. Бага зэрэг ид шидийн мэт мэдрэмж.

Арцны мансуурам утаа дуниартаж, хэдэн метр урт эвэр бүрээ болон бөмбөрийн уйтгартай цохилтонд орж ирэх тэр орчны нөлөөг би төсөөлж байна... Эсвэл шөнө дундын нам гүмд, амаа ангайлгасан лууны толгой дээр сарны гэрэл тусна. Ийн явах зуур



Эрдийгийн “Дарвитиз могой ба эр зоригт Татар” гэдэг үлгэр санаанд оров: Бяцхан шар могойг аврагч хээрийн хоньчин (шаргашарик нь монголоор шар, гүег-гэдэг нь көеөк) луун могойн хааны агуйд орохдоо хоёр талаасаа салаалсан толгойтой аварга луу мэт могой байхыг харжээ. Өөр нэгэн ардын үлгэрт, Төмөр Лоци луун могойн хаанаас хүлэг морь, шидтэй илд, (хөө хуяг) цамц бэлгэнд авдаг. Хүлэг морьд нь зөвхөн уналганы морьд байгаагүй, тэд эзэддээ ямагт сайн зөвлөгөө өгч тусалдаг морьд төдийгүй дайн тулаанд гэгээн Ласлогийн Сөг нэртэй морины адил дорнын баатруудын сайн хүлэг нь байсан.

Морин тулааны дүрслэл бүхий анхны дүрслэлийг Ордосоос олдсон Скифийн хүрэл олдвор дээрээс харж болно. (Хятадын цагаан хэрэм болон Шар мөрний хоорондох нутаг).

Унгарчуудын нүүдлийн үеийн Коцкий-городок-ийн төмөр аяган дээр дайчид морьдоосоо тусламж гуйж байгаа мэт дүрслэгдсэн байдаг бол Шепшикиен болон Бөгөзийн (эдгээр газрууд нь Сикй нутагт байдаг) гэгээн Ласлогийн домгийг дүрсэлсэн ханын зурган дээр морьд нь бие биенийхээ хүзүүг хазаж буйгаар дүрслэгдсэн байдаг. Энэ нь бүстэй бөхийн барилдаанаас гадна олон мянган жилийн тэртээх Унгарчуудын дорноос авсан уламжлал юм. 2017 оны 10-р сарын 28-нд Сикэйудвархей хотын иргэний танхимд болсон бага хурлын үеэр надад төрсөн онцгой сэтгэгдлүүдийн нэг нь Унгар дахь дорно дахины эртний өв соёл нь ХХ зуун хүртэл хэр сайн хадгалагдан үлдсэнийг мэдрэх явдал байсан. Энэ нь гэгээн Ласлогийн домгийн тухай, зэвсэггүй тулаан буюу нүүдэлчдийн бүстэй бөхийн барилдааны тухай юм. Тухайн үед Пал Ласло хэмээх 78 настай, Дьердюосархедед төрсөн эрэгтэй хүмүүсийн дундаас гарч ирээд, залуу ахуйдаа Марошын эрэг дээр малаа бэлчээж явахдаа байнга л “бүстэй бөх барилддаг” байсан тухайгаа ярьсан. 2500 жилийн тэртээгээс оршин байсан тулааны төрлөөр тэд Марошын эрэг дээр бэлтгэл хийдэг байсан бөгөөд энэхүү бүстэй барилдааны талаар Ордос нутгаас олдсон МЭӨ VI зууны Скифийн үеийн хүрэл цутгамал дээр дүрслэгдсэн байдаг.

Угсаатны зүйн археологийн судалгааны үнэ цэнийг зарим судлаачид хүлээн зөвшөөрдөг бол зарим нь санал нийлдэггүй. Олон талт бодит судалгааны үр дүнгээр уламжлалт археологийн олдворуудыг баяжуулах хэрэгтэй хэмээн бодож байна. Льюис



Бинфорд нь 1969-1973 оны хооронд Аляскийн хойд хэсэгт орших эскимосчуудын (өөрсдийнх нь нэрээр Инуит) дунд нэлээд хугацааг өнгөрөөсөн. Бинфордын ажиглалт нь олдворуудад бодит дүгнэлт гаргахад, тэр ч байтугай үйл явц бүрийг танихад маш их хэрэгтэй болсон. Малчид, дэлхийн 2-р дайнд оролцсон хүмүүс мөн ахмад дархчуудаас багаж хэрэгсэл (зэвсэг, багаж хэрэгсэл) ашиглах, хийх талаар маш их зүйлийг би сурч мэдсэн. Туршилтын археологийн судалгааны хувьд ч нөхцөл байдал ижил байна. Үүний зэрэгцээ хангалттай “шинжлэх ухаанч” гэж үздэггүй “өрөөний эрдэмтэд” ч байдаг.

Мөн археологи, угсаатны зүйн мэргэжил эзэмшээгүй байж өөрсдийгөө “туршилтын археологичид” (бодит байдал дээр ийм зүйл байдаггүй, ийм хөтөлбөр аль ч их сургуульд байдаггүй) гэж үздэг судлаачид байдаг. Туршилтын археологи нь янз бүрийн мэдлэг, ур чадвар бүхий мэргэжилтнүүдийн багийн ажлын үр дүнд бодит үр дүнг гаргах боломжтой боловч тэнд археологич зайлшгүй байх шаардлагатай.

Миний хувьд, 25 гаруй жилийн судалгааны ажлаараа тал хээрийн нүүдэлчдийн зэр зэвсэг эзэмших аргыг амьдрал дээр туршиж судалсан юм. Мориор болон явганаар, өвөл зуны сайн, муу цаг агаарын алинд ч судалгаагаа хийсэн. Бэлтгэлийн үед болон судалгааны явцад хэд хэдэн удаа хүнд бэртсэн, энэ нь бид судалгаануудаа аль болох бодитойгоор хийхийг хичээсэн, зорьсонтой холбоотой. Судалгаагаараа зарим буруу ойлголтыг ч үгүйсгэж чадсан. Хөө хуягийг 50 метрийн зайнаас 65-80 фунтын хүчтэй сумаар харваж болно. Тиймээс IX-X зууны үед баруун зүгийн аян дайнуудад Унгарчуудын сумыг хөө хуяг хамгаалддаггүй байсан. Дайчдын хувьд богино жадаа мөрнийхөө ар хэсэг нуруундаа сураар бэхлэн байрлуулах нь хэрэгцээтэй үед гаргаж ирэн ойрын зайн тулаанд ашиглах мөн нум сум харвахад тохиромжтой. Сүхээр болон зээтүүгээр дайсныхаа толгой буюу дуулгыг цоо цохих боломжтой ч хурдлан давхиж буй морин дээр зэвсэг эргүүлэх нь хүндрэлтэй. Ийм учраас зэр зэвсэг нь мохоо, бөөрөнхий ирмэгтэй, эсвэл хоёр удаа сунгасан “S” үсэг хэлбэртэй цохих гадаргуу нь “хурц үзүүртэй” зэвсгээс илүү давуу талтай байдаг бол “хурц үзүүртэй” зэвсэг нь хүний биед илүү гүн шигдэн сугалж авахад хэцүү байдаг. Цайзыг хамгаалж буй явган цэргийн



хувьд энэ нь асуудал биш юм. Богино үзүүртэй жижиг зэвсгийг ямар ч хүндрэлгүйгээр сугалж болно, харин бат бөх зузаан дуулгыг нэвт цохиж чадах эсэх нь эргэлзээтэй. Сэлмээр цавчилдах явцад үзүүрээр нь хатгаад буцааж авахад дайсныхаа бугуй болон шууны хэсгийг гэмтээх ба довтлох үедээ доороос өлгөсөн хөдөлгөөн хийхэд дайсныхаа зэвсгээ барьж буй гарын хуруунуудыг таслах боломжтой. Би үүнийг “тулааны бодит нөхцөлд” ч мэдэрсэн ...

Анхны төрт улсаа байгуулсан унгарчуудын 17-24 см-ийн урт иртэй сэлэмнүүд нь дээр дурдсан тулааны үед маш тохиромжтой. Ханы сэлэм Атиллагийн илдний ирний хэсгийн урт нь 49 см байсан. Илдний ирний урт нь зөвхөн хатгаж дүрэхэд зориулагдсан гэсэн аман ойлголтыг няцааж байна. Нэр нь хүртэл “илдний үзүүр” биш илдний ир юм...

Унгар ханы сэлэм нь IX-X зууны үед хийгдсэн бөгөөд Алмош эсвэл Арпадынх байж болох юм. Энэ нь I Андраш хааны үе хүртэл шинэ хааныг хаан ширээнд залах, титмээ авах ёслолд зориулсан зэвсэг байсан байж магадгүй. Ирний ховил дахь дөрвөн луугийн дүрслэл, маш гоёмсог алтадмал иш, хуй зэрэг нь энэ сэлэмийг хааны зэвсэг байсныг гэрчилнэ. Илд болон сэлэмийг дээдлэх үзэл нь МЭӨ 6-р зуунд тал хээр нутгийн морьт нүүдэлчдийн дунд үүссэн. Херодот скифчүүдийн илдний шүтлэгийн тухай тэмдэглэсэн бол Хүннүгийн их хаан Атиллатай холбоотой Бурханы илдний тухай алдартай домог, Византийн түүхч Еугариос илд болон сэлэмтэй холбоотой Аваруудын итгэл үнэмшлийг дүрсэлсэн байдаг.

Унгарчуудын хувьд шинэ хааныг ширээнд залах буюу хааныг титэмлэх ёслолын үеэр шинэ хаанд сэлмийг гардуулснаар тэрээр дөрвөн зүгт хамгаалалтыг бэлгэшээж, цавчих зан үйлийг хийдэг байсан. (1916 онд IV Карой хаан энэ зан үйлийг гүйцэтгэсэн) Чингис хааны цэрэгт Монголчуудын дунд илд-сэлэм хариуцсан илдэч нэртэй албан тушаал байсан. Киданчуудын дунд шүүх эрх нь хааны бэлэглэсэн илдтэй холбоотой байсан. Мамлюкууд ба Османы туркуудын дунд сэлэм нь засаглалын бэлгэдэл байв.

Унгарын ханы сэлэм одоо Вена дахь музейд байгаа бөгөөд тайлбар дээр нь “Энэ бол Халиф Харун аль Рашидаас өгсөн их Карой хааны илд”! гэж байдаг. Энэ нь Шинжлэх ухаанаар батлагдахгүй ч, ёс зүйг хөндсөн асуудлууд юм.



Герман лам Хэршфилди Ламбертийн тэмдэглэснээр, 1063 онд I Андраш хааны бэлэвсэн эхнэр Анастасия Арпадын эрдэнэсийн санд хадгалагдаж байсан Атиллагийн алдартай сэлмийг Баварийн хунтайж Нордхэймийн Отгод бэлэглэсэн. Энэхүү сэлэм нь 1440 он хүртэл буюу III Фридрихийг хаан ширээнд суутал хааны титэмлэх ёслолын гол бэлгэдэл байсаар байсан. Энэхүү ёслолын зан үйлийг Германы хаад Унгарчуудаас авсан бөгөөд үүнээс өмнө тэдний ёслолын бэлэгдлийн зэвсэг нь жад байжээ. Унгарын энэхүү гоёмсог сэлэмний чимэглэл нь Гестерид, Ракамаз, Тарцалын сэлэмний хийцтэй төстэй. Ир, шигтгээ боловсруулах арга нь Асуд болон Будапештийн Сентлөринцийн сэлэмний хийцтэй төстэй. Тэгэхээр сэлэм Унгарынх байсан гэдэгт эргэлзэх зүйлгүй.

Алдартай Эрдэнэзуу хийдийн эргэн тойронд зам тавигдаж байна. Удахгүй энэ ч гэсэн аялал жуулчлалын томоохон цэг болно. Бидний хувьд ахиад л мартагдсан мөрөөр явах хэрэг гарна.

Удалгүй бид эгц өндөр нүцгэн ууланд авирав. Сүүлийн хэдэн зуун метрийг бид явганаар туулсан. Энд Түрэгийн үеийн цайзын туурь байх бөгөөд тэгш газарт 50x30x15 см-ийн хэмжээтэй чулуугаар барьжээ. Цайзаас бүх зүг рүү алсыг харж болохоор барьсан нь стратегийн ач холбогдолтой мэт.

Дахин хүчтэй салхилж, бид цайзаас буухаас өөр аргагүйд хүрэв. Цааш хагас цаг яваад Монгол, Турк хоёр улсын хамтран бүтээн байгуулсан Билгэ хааны музейд очив. Залуу байхдаа олон удаа уншиж байсан руни бичээстэй Орхоны хоёр гэрэлт хөшөө, Билгэ хаан, Күльтегин хоёрын тухай баримтыг энд үзсэн нь миний хувьд маш аз завшаантай хэрэг байлаа. Зүүн Түрэгүүдийн тусгаар тогтнолын төлөөх тэмцлийн дурсгалд зориулсан чулуун гэрэлт хөшөөнүүдийг 730-аад оны үед Орхон болон Туул голын эрэг дээр босгожээ. Кутлуг-Элтерэс хаан тэргүүтэй зүүн түрэгүүд 680-687 оны хооронд амжилттай тулалдсаны эцэст Хятадын дарлалаас ангижирсан. Элтерэсийн хүү Билгэ хаан бөгөөд түүний гол түшиг тулгуур нь дүү Күльтегин байв. Тэрээр 685 онд төрж, 731 онд нас баржээ. Билгэ хаан болон Күльтегины чулуун гэрэлт хөшөөний гурван талд нь түрэг хэл дээр руни бичгээр, үлдсэн нэг талд нь хятад ханзаар бичсэн бичээс бий. Газар унасан байсан гэрэлт хөшөөнүүдийг XIX зуун буюу 1890 онд илрүүлсэн. Гэрэлт хөшөөний анхны хуулбарыг (чулуунд сийлсэн бичээс дээр



нойтон цаасыг тавьж бичиг, хээг нь хуулж авах арга) Катанов (Казаньд сурч, амьдарч байсан хүн) хэмээх монгол эрдэмтний эхнэр хийсэн гэдгийг өнөөдөр батлах эсвэл үгүйсгэх аргагүй юм. Залуу монгол бүсгүй Казань хотоос Орхон гол руу явах мөн буцах адал явдалтай, эрсдэлтэй аяллыг хоёр жилийн хугацаанд хийжээ. Гэрэлт хөшөөний бичээсийн хуулбарыг сүүлд 1983 онд Данийн хэл шинжлэлийн эрдэмтэн В.Томсен баяжуулан утгыг нь тайлсан байна. Хятадын мэдэлд байсан энэ газар руу европчууд явахад аюултай үед монгол эмэгтэй очсон. Шведийн туршлагатай аялагч, судлаач Швен Хединий бүтээлүүдээс Хятадын нутаг дэвсгэрт аялагчдад ямар их аюул, бэрхшээл, дарамт учирдгийг харж болно.

Музейд VI-VIII зууны үеийн түрэгүүдийн археологийн дурсгалуудыг дэлгэн үзүүлсэн байна. Тэнд байх бүс, бүсний арал нь Аваруудынхтай төстэй бөгөөд энэ нь тэдний соёл ижил төстэйг харуулж байна. Алт, мөнгөөр урласан буган баримлууд нь амьд мэт, анатомийн хувьд нарийн бөгөөд дархан нь олон буга харсан бололтой. Алтан титэм нь Билгэ хааных байх магадлалтай. Харин миний хувьд морин харваачдыг дүрсэлсэн чулуун баримал, дээврийн хавтан л чухал байсан. Дээврийн саарал хавтан дээрээс хоёр төрлийн нумыг харж болно. Нэг нум нь урт, хатуу гартай (эвэр нум), нөгөө нь богино. Энэ бүхнээс харахад “Осман-Турк”-ын нумтай төстэй нум сум тэр үед байсан байна.

Морьтнууд морины давхил дундаа эргэж харан харвадаг. Энэ нь өнөөдөр Төв Азийн бус нутагт танигдсан нум сумны тэмцээн бөгөөд байгаа өндөр модон дээр байршуулан харвадаг. Османы Түрэгүүд ч мөн сургуулилтандаа ийм зан үйл хийдэг байжээ. Уран баримлууд дээр бэлтэй бүс, оосор бүрээс бүхий бүсэнд зүүсэн хутга дүрслэгдсэн байдаг.

Баатруудын хаггалдах зэвсэг нь сэлэм гэхээс илүү илд мэт. Бариул нь Алмош, Арпадын цэргүүдийн сэлэмний бариул шиг ирмэг рүүгээ бага зэрэг тахийсан байдаг. Нэг ийм зэвсэг X-XII зууны үед хамаарах Киданы үеийн хадны булшнаас олдсон. Мөн энэ булшнаас маш сайн хадгалагдан үлдсэн тоноглолтой бүс, гутлын улавч, нум, холтос модоор хийсэн саадаг, 10 ширхэг сум (тэдгээрийн өднүүд нь хүртэл үлдсэн байсан, 2021 онд Монголын Археологийн хүрээлэнд танилцах боломж олдсон нь археологи



болон тулааны урлагийн үүднээс авч үзвэл маш их сургамжтай зүйл болсон), эмээл, хос дөрөө, хазаарын төмөр амгай гарсан. Модон авсанд оршуулсан Кидан дайчны булшнаас мөн хусан иштэй ташуур олдсон. Гэхдээ хамгийн чухал нь бүсний хавтагууд байсан. Хөшөөнүүд дээрх хавтага нь баруун гар талд, бага зэрэг ард байрласан байсан. Энэ нь зангидсан оосортой туузан дээр бэхлэгдсэн байсан. Хавтаганы хэлбэр, хэмжээ нь Унгарынхтай төстэй. Хэдийгээр эдгээр хөшөө нь VI-VIII зууных боловч Х зууны Кавказын зурагнууд дээрээс харж болох учир хавтага нь тал хээрийн нүүдэлчдээс гарал үүсэлтэйг тодорхой нотолж байна.

Монгол улсын Дарьганга нутагт мөн бүснийхээ баруун талд унжсан зангилаатай, суугаа байрлалтай сийлбэр чулуун хөшөөнүүд байдаг. Хавтаганы нүүрэн хэсэгт чимэглэл сийлсэн байдаг. Чулуун хөшөөнүүдийг эрдэмтэд XIII-XIV зууны үеийнх хэмээн тогтоосон.

Киргизийн нутагт хавтаганы чулуун хөшөө байдаг. Тура-Су горхины хажууд түрэг, ялангуяа хөх түрэгийн дайчин бүсгүйг дүрсэлсэн нэгэн чулуун хөшөө байдаг. Нүүдэлчдийн энгийн хувцас өмссөн дайчин эмэгтэй бүсэндээ сэлэм болон хавтага зүүсэн байдаг. Өргөн өмдний шуумгийг гутландаа чихэн баруун гартаа аяга барьсан байдаг.

Баруун Монголд, голдуу Өлгий хавьд Түрэгийн үеийн хүн чулуу бүхий чулуун хөшөө олон байдаг. VI-X зууны хооронд босгосон Түрэгийн үеийн хүн чулуу болон X-XIII зууны үед босгосон кумануудыг дүрсэлсэн хүн чулуунуудын хоорондын гол ялгаа байдаг. Куманчуудын хөшөөний хувьд аягаа хоёр гараараа хүйснийхээ дээр барьсан байдаг бол түрэгүүд ихэвчлэн ходоод, цээжний хавьцаагаа баруун гартаа хундага, таягаа барьсан байдаг. Гэхдээ хоёулангийг нь хувьд бүс, бүсэнд зүүсэн эд зүйлс болон хүний гарыг тодоор ухаж сийлсэн байдаг.

XIX зууны үед Эрдий нутгийн Хавадтю, Хармошфалу, Кибид зэрэг газруудад үүнтэй төстэй оршуулгын чулуун хөшөөг хийдэг байсан нь огт санамсаргүй зүйл биш юм. Биеийн урд хэсэгтээ барьсан гар, бүс, нүд, сахал зэрэг нь Сикэй нутгийн чулуун хөшөөнүүд дээр тод дүрслэгдсэн байдаг нь тал хээрийн нүүдэлчдийг дүрсэлсэн хүн чулуун хөшөөнүүдтэй төстэй юм.



Тэр ч байтугай 1885 онд ийм чулуун хөшөөг Хавадтюд нэгэн реформат оршуулган дээр бүтээсэн байдаг. Энэхүү чулуун хөшөө Керекеш Петрийн булшин дээр байдаг. Ойролцоох Няародын хаалганууд, булшны чулуун дээр буга, луу, могой, арслан, амьдралын мод болон онцгой шувуудын дүрс маш олон байдгаас энэ нь эртний тэмдгүүд гэдэг нь харагддаг. Нар, сарыг гоёмсгоор дүрсэлсэн нь үзэсгэлэнтэй харагддаг. Энэхүү бүс нутгийн онцлог шинж чанартай хээ угалз нь скиф, авар болон унгарчуудын төрт улсаа байгуулах ухагдахуун сэдлийн үргэлжлэл юм. Энэ талаар эрдэм шинжилгээний, шар үс босгом мэтгэлцээнийг зохион байгуулж болох ч томьёолох зарчим, хэрэгжүүлэх арга зам нь тодорхой байдаг. Энэ бүхэн нь ижил сэтгэлгээ, “ертөнцийг үзэх үзэл” гэсэн үг юм. Олон нарийн ширийн зүйлс нь хоорондоо тохирч, санамсаргүй тохиолдол бүрийг үгүйсгэдэг. Сүмийн ханан дахь Гэгээн Ласлогийн зуруулсан зэвсэггүй тулаан (барилдах), загасны уурга, цорын ганц эмзэг цэг болох бүсгүй (эмэгтэйн хүч), тулааны дараа модны дор амарч буй, зэр зэвсэгт гэмтэхээргүй бие бүхий зургууд нь скифчүүдийн эрин зуунд аваачдаг. Карпатын сав газар дахь Гэгээн Ласлогийн бүрэн бүтэн бус үлдсэн 80 орчим ханын зураг нь XIII-XV зууны үеийн унгарчуудын тухай юм гэдгийг энэ бүхэн баталж байна. Чекефолвод (Сикэй нутагт) XVII зууны нэгэн зуухны хавтан дээрээс Гэгээн Ласлогийн “бүсгүйг хулгайлагч куман” зурагнаас тухайн хүний бүрэн зэвсэглэлийг харж болно.

Унгар судлалын хүрээлэнгээс олон жилийн өмнөөс хийсэн археогенетикийн судалгааны үр дүн нь скифүүд, хүннүүд, аварууд, унгарчууд болон монголчуудын хоорондох залгамж холбоог баталж байна. Энэ нь хоёр мянга гаруй жилийн холбоо хамаарал юм. Үүнийг эртний хээ угалз мөн ардын үлгэр, туульс хайлахад хэрэглэгддэг үг хэллэг ч батална. Тухайлбал, тэнгэр шүргэм модод, жигүүртэй морь, гол баатар адал явдлаас өмнө нойрсох, ертөнц хоорондын жигүүртэй морины аялал (дээд доод ертөнц, оройгүй мод 77 дахь мөчир дээр), нүцгэн гараараа тулалдах, үгийн эхэнд үсэглэх, гурван үгийн тодотгол (үхлээр үхэх) эсвэл хамгийн жижиг ханхүүгийн ялалт зэрэг. Эрдий нутгийн Калотасегт айлын бага хүү нь өндөр настай (бусад нь мөн эцэг эхээ асран халамжлана) эцэг эхийгээ халамжлан гэрт нь амьдардаг бөгөөд аавынхаа эд зүйлсийг өвлөн авдаг. Монголчуудын хувьд ч



мөн адил. Хамгийн бага отгон хүү нь гал голомтоо манадаг тул отчигин гэдэг. Цагаан хааны отгон хүү эцгийнхээ багын андал туслахын тулд түүний тавин жилийн өмнө дайнд явахдаа өмсөж байсан хувцсыг өмсөн зэр зэвсгийг нь агсаж, морио тоноглон алс хол наран ургах зүг хөдөлдөг нь санамсаргүй зүйл биш юм. Тэрээр дагинын зөвлөснөөр жигүүртэй хүлгээ хөлөглөн явдаг. “Фиртошын морь” хэмээх домогт, дагина газрын хөвгүүнтэй уулзахын тулд түүнд жигүүртэй хүлэг морь бэлэглэдэг бол морин хуурын тухай монгол домогт мөн адил хүлэг морь бэлэглэдэг. Энэ хоёр домгийн аль алинд нь газрын хүүгийн хайхрамжгүй байдлаас шалтгаалан хүлэг морь нь үрэгдэн, дагинатай цаашид уулзах боломжгүй болдог...

Энэ бүх бодол Билгэ хааны дурсгалт газар, түрэгийн чулуун хөшөө, бичээст багана, алт, мөнгөн бугануудын дунд байх үед толгойд минь бус сэтгэлд минь аянгын хурдаар эргэлдэж байв.

Дараа нь дахин цааш явсаар л. Асар том нүцгэн толгод, уулс. Өндөр, урт даваа бүрийг өгсөхөд цаг гаруйн хугацааг зарцуулна. Монголчууд машиныг их чадварлаг жолооддог юм билээ. Уул өөд өгсөх нь (сикэй нутгийнхан өгсөхийг фелитү гэж нэрлэдэг бол уруудахыг лейтү гэж нэрлэдэг) биднийг гайхшруулж байлаа. Замын бартаа саад монгол жолооч нарын хувьд ямар ч асуудал биш. Алтай, Тарвагатай, Тэнгэр уул (Тянь-шаны уулс) нь Чингис хаан, Сүбэдэй, Батын цэрэг дайчдад асуудал биш байсан. Ижил мөрөн, Дон, Днепр, Дунай, По, Рейн, Сена гол мөрнүүдийн аль нь ч монгол дайчдад болон унгар, авар, хүннү морьтнуудад саад тотгор болж байгаагүй юм. Тал хээр нутгийн морьтнууд Кавказын уулс, Карпат, Альпийн нурууг өвлийн тэххийм хүйтэнд ч давдаг байсан. Түүхэн цаг хугацаануудад гагцхүү тал хээрийн морьтон дайчид л ийм хол зайнд бартаа ихтэй замуудыг цаг агаарын таагүй нөхцөлд ч ажрахгүй туулж чаддаг байжээ. Энэ бүхэн нь мэдээж асар их мэдлэг, зохион байгуулалтын ур чадвар, сахилга бат шаардаж байсан. Зөвхөн дайчид морьдыг хоол, унд усаар хангаж, олон мянган км урт замыг туулахад логистикийн маш өндөр ур чадвар (цэргийн толгойн сэргийлэх, тагнуул, байлдааны ажиллагаа, зэвсэгт хүчний хангамж, нөхөн сэргээлт, шархадсан цэргүүдийн арчилгаа тордолгоо, цэргийн хуаран босгох) шаардагддаг байсан. Энд тулааны талаар өгүүлсэнгүй.



Янз бүрийн ард түмний цэрэг армийг харьцуулах нь утгагүй бөгөөд үл хүндэтгэсэн хэрэг хэдий ч Ром эсвэл Франкийн армийн байлдааны үнэ цэнэ, зохион байгуулалтын талаар ярьдаг хүмүүсээс би зүгээр л асууя: Ромчууд хэзээ Дон, Ижил, Сырдарья мөрнүүдийг гаталсан бэ? -Харин Хүннүчүүд эдгээр гол мөрнүүдийг гаталсан байдаг. Франкууд хэзээ Тураны хөндий, Зүүнгарын сав газарт хүрч ирсэн бэ? -Харин Аварууд өнөөгийн Францад хүрч очиж байсан. Түүхийг сонссоноороо гуйвуулж, давхар стандарт баримтлахгүйгээр бодитойгоор дүн шинжилгээ хийх цаг болсон байна.

Уулсыг өгсөж, уруудах явахад хязгааргүй хөх тэнгэр л биднийг бүрхэн нөмөрнө. Баяннуурын ус цэвэр учир шууд ууж болно. Монгол судлаач нөхөд маань бүгд нуурын усанд нүүрээ угаацгаана. Энд ирэх үед ийм заншилтай гэдгийг тэд хэлсэн. Тэгээд бид ч бас нүүрээ угаацгаасан. Эрдий нутагт миний багад ууланд, гол, горхи, нуурын эрэг дээр бид яг л ингэдэг байсан. Тэр үед яагаад өдөрт дөрөв, таван удаа нүүрээ угаах ёстойг ойлгодоггүй байсан. Энэ газар бүхэлдээ Эрдий нутгийн Летагийн цайзын эргэн тойрон дахь үржил шимгүй, хадархаг уулс эсвэл Мезүшигийн толгодыг санагдуулна. Ялгаа нь гэвэл манай нутагт уулын хөндий, ой, толгодын дунд машины мөрөөр гарсан зам биш, төмөр зам байдаг. Би 12-14 настай байхдаа Унгарчуудын эртний түүхийн тухай номноос Культегины гэрэлт хөшөөний бичээсийг унгар орчуулгаар анх уншиж байсан. Түүнчлэн найзуудтайгаа хамт Лета цайзын нүцгэн хадархаг газруудад нум сум, жад барин Культегины түүхэнд гардагчлангаар тоглодог байсан. Одоо би харин жинхэнэ тэр газарт нь хүрч ирээд байна.

Нуурын цаана ихэвчлэн том уул байх бөгөөд энэ нь усны хагалбар юм. Тэгээд дахиад л асар өргөн уудам эзгүй тал байна. Алсад цайзын туурь, хэдэн гэр, жижиг байшингууд харагдана. Нааш ирэх зам зуур олон удаа харсан шиг малчид морь эсвэл мотоциклоор малаа хариулна. Мал нь өвлийн ноос, ноолуур хөөвөртэйгөө байна. Шөнөдөө -6 хэм хүртэл хүйтэн, салхи маш хүчтэй байдаг тул гайхах зүйл алга. Өвлийн ноос, ноолуур хөөврөөс гадна адуу, мал, үхэр, ямаа нь манайхаас илүү тарга хүчтэй байдаг. Бид олон газарт уулын оройд, овоон дээр морины гавлын яс байгааг харсан. Зарим газарт, хээр тал дээр малын



араг яс бүхлээрээ байхтай ч таарсан. Тэдгээр амьтад чоно, зэрлэг нохойнд бариулсан эсвэл цаг агаарын хатуу ширүүнийг гэсвэрлэж чадаагүй. Монголын өвлийг хайхрамжгүй залхуу хүн даван туулахад хэцүү!

Нэг цагийн дараа бид Киданы дурсамжийг хадгалсан суурингийн туурь, жижиг музейд хүрэв. Энэ нь Кидан болон Манжийн цайзын туурь юм. Чулуун хана хэрэм босгосон арга нь европ биш түрэгүүдийнхтэй төстэй. Бага зэрэг эл хуль гэмээр жижгэвтэр энэ музейд маш гайхалтай гэнэтийн зүйл тохиолдов. X-XII дугаар зууны үеийн хоёр ширхэг шүдний сойз саванд харагдаж байна. Урт нарийн модны урд талд нь зэрэгцүүлэн зургаан нүх гарган амьтны үс наасан байна. Дундад зууны үед киданчууд Төв Азид шүдээ угаадаг байсан байна! Византийн эзэн хаан Константины 948 онд бичсэн унгарчуудын нүүдлийн тухай тэмдэглэл гэнэт санаанд орж ирсэн бөгөөд тэр үед Булчу, Тормаш жанжид Константиннапойд байсан байна. Унгарын түүхийн сурах бичигт яагаад энэ тухай байдаггүй вэ? Бодит байдал, нэг хэсгийнх нь хувьд гал шиг хурц сэдэв болох шашны талаар, Монголчууд дэлхийн олон шашны тухайд баримталж байсан өв тэгш бодлогын талаар яагаад оруулаагүй юм бол? Магадгүй, “азийн нүүдэлчид” нь Хятад, Визант, Франкуудын соёлоос суралцсан “зэрлэг бүдүүлэг нүүдэлчид” биш болох нь тодорхой болох гээд байсан юм болов уу? Монголын жижигхэн музейд байгаа хоёр шүдний сойз бол сэргээн засварласан зүйлс биш археологийн олдворууд юм. Энэ бол биет нотлох баримт.

Нум сумны зэв, нумны яс, шатаасан шаазан дээврийн хавтан, ясан болон төмөр эд зүйлс нь тал нутгийн нүүдэлчдийн онцлогийг харуулсан эд зүйлс юм. Мэдээж хэрэг, эдгээр төмөр ялтсууд болон эдлэлүүд нь сонирхолтой түүхтэй байх ба Австри-Унгарын цэргийн төмөр эдлэлтэй их төстэй юм. Металл ханцуйны төгсгөлд дугариг хэлбэртэй зүүмэл хэсэг, тусад нь тоноглон хоолойн хэсэг, оосрын бэхэлгээний төмөр ялтас нь ихэвчлэн k.u.k. цэргийн тоноглолтой төстэй. Үүнийг Монголын тал хээр нутагт хэрхэн бэлтгэсэн байж болох вэ? Энэ нь өнөөдрийг хүртэл нэр нь тодорхойгүй бүтээл нээгчийнх байсан уу эсвэл Сибирийн цөллөгөөс зугтан Монголд очсон олзны унгар цэргийн бүтээл байв уу? Гелета Йозефийн түүхээс үзвэл хоёр дахь хувилбар нь боломжгүй зүйл биш юм...



Оросын олзны цэргийн хуарангаас амжилттай оргосон Гелета Йозеф есөн жилийн турш Монголд амьдарсан. Тэрээр анчин, адуучны амьдралаар амьдарч, дээрэмчид болон хятадын түрэмгийлэгчдийн эсрэг тэмцэж, улмаар Монголын Засгийн газрын итгэлийг хүлээсэн хүн болж чадсан. Тэрээр Өргөө хотын цахилгаан станцыг барилцаж, Парламентын ордны зураг төслийг хийж, Их сургуулийн багшаар томилогдон ажиллаж байсан. Мөн Монголд европ хүний мөр нь ч гараагүй газруудаар очиж, гадны ямар ч хүний үзээгүй зүйлсийн зургийг авсан. Тэр үед ч, одоо ч гэсэн монголчууд унгарчуудыг холын ах дүүсээ гэж үздэг. Унгар судлалын хүрээлэнгийн археологи генетикийн судалгаагаар Хүннүчүүдийн (Азийн Хүннүчүүд)-ийн генийн тодорхой бүлэг унгар, монголчуудын аль алинд нь байдгийг тогтоосон.

Бид судалгааны аяллынхаа үеэр зуун жилийн өмнөх Гелета Йозефтэй адил төстэй зүйлийг мэдэрсэн. Монгол судлаачид өөрсдөө ч үзэх боломж хомс Монголын үндэсний банкны Эрдэнэсийн санд Гол модны Хүннүгийн хааны булшнаас олдсон үнэт металл эрдэнэсийг үзэх боломж бидэнд олдсон. Бидний судалгааны аяллыг дэмжигч төдийгүй судалгааны хамтрагч Унгар Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Др.Обрущанский Борбалад онцгойлон талархлаа илэрхийлье.

Монгол Улсын ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн сэргээн засварлах хэсэгт хадны булшнаас олдсон бүрэн бүтэн шахам үлдсэн зэвсэг, хувцас болон бусад хэрэгслийг шинжлэн судалсан. Хэмжилт хийн, зурлага зурж, зураг авах боломж олдсон. X-XIII зууны үеийн нум сумны саадган дээр Европт өнөөг хүртэл хэн ч харж байгаагүй нарийн ширийн зүйлийг ажиглах боломж олдсон. Морины нуруун дээрээс харваж сурсан миний хувьд бэхэлгээний хоёр хавчаар нь их биен дээр байх нь практик талаасаа чухал байсан байна. Дээд талын хавчаар нь нэг шугаман дээр эсвэл доод талынхтайгаа ижил өнцгөөр бэхлээгүй байсан. Ингэснээр морь унахад нум сумны саадаг морь унаж буй хүний хөлд болон морины хоёр тал руу цохигдох нь багасах юм. Мөн сумнуудыг илүү амархан сугалж болно. Сумнуудыг доош болон дээш нь харуулан байрлуулсан нум сумны саадаг олдсон байдаг. Унгарт Икервар Вираг гудамжны унгарчуудын төрт улсаа байгуулах үеийн булшнаас олдсон олдворууд дээр энэхүү сумаараа саадгаа



дүүргэх хоёр арга адилхан байдаг. Үүнийг нэгэн оршуулгын газарт ажиглаж болох боловч тэнд зөвхөн нум сумны зэв, саадагны төмрийн хэсгүүд л үлджээ. Гол нь унгарчууд болон монголчуудын аль аль нь энэхүү хоёр саадгаа сумаар цэнэглэх аргыг хоёуланг нь ашигладаг байсан байна. Эдгээр хадны булшнуудад зөвхөн 1-3 сумыг бэлгэдлээр саадагт хийгээгүй, харин олон сум хийсэн байдаг. Иймээс сумнууд нь саадаг дотроо дээш эсвэл доош харуулсан байрлалтай байсан тал дээр “академик мэтгэлцээн” хийх нь утгагүй юм. Саадаг дотор хорь гаруй сумны өд бүрэн бүтэн үлджээ. Сумны хэлбэр, бэхлэгдсэн байдал зэргийг эндээс сайн ажиглаж судлах боломжтой. Хэдхэн хоногийн дотор тал нутгийн нүүдэлчдийн зэвсгийн талаар сүүлийн хорин жилийнхээс илүү их мэдээлэлтэй болж чадсан. Монгол археологичид болон сэргээн засварлагчид надад үргэлж тусалж байснаас гадна миний урам зоригийг хараад чин сэтгэлээсээ баярлаж байсан. Миний туршлага Гелета Йозефынхтэй адил төстэй байлаа. Евроазийн хязгааргүй тал нутгийн хоёр захад амьдарч буй ард түмэн бие биенээсээ их зүйлийг сурч, бие биедээ тусалж чадна гэж бодож байна. “Монголын нууц товчоо”-ны хэдэн мөр санаанд бууж байлаа:

“Бид ам, хэлээрээ ярьдаг ч  
Зүрх сэтгэл бие биенээ ойлгодог.”

Бидэнд зөвхөн оюун ухааны төдийгүй зүрх сэтгэлийн холбоо байдгийг би Монголд байхдаа олж мэдэрсэн. Бид зөвхөн судлаачид төдийгүй зүүн, баруун хязгаар дахь тал хээрийн морьт нүүдэлчдийн соёлыг сахин хамгаалагчид билээ. Грекийн агуу түүхч Херодот Скифчүүдийн тухай ийнхүү бичсэн байдаг: “Хэдийгээр скифчүүд нэг хэлээр ярьдаггүй, нэг улсад амьдардаггүй ч тэд алс хол амьдарч буй ард түмнүүдийг скиф мөн бишийг ялгаж чаддаг байсан” гэж бичжээ. Төмрөөр хийсэн хутганы хуй нь анх хийгдсэн газраасаа хол газраас олдсон боловч “скифээс скифид байсан” байна.

Музейгаас гараад бид Улаанбаатар руу буцахаар хөдлөв. Хэсэг явсны дараа Киданы Чин Толгой (Чен-Чу) хотын туурийн дэргэд нэлээд том курган буюу бунхан байхыг үзэв. Түүхэн мэдээллээс үзэхэд, эрт дээр үед энэ хотод 20 мянга гаруй Кидан дайчин, 700 хятад, зүрчид өрх амьдарч байжээ. Өнөө үед зөвхөн



урт шороон далангийн үлдэгдэл, нурсан суваг шуудуу л хотын хэмжээг илтгэнэ. Яг л Уйгарын нийслэл Орду Балик хот шиг асар уудам хээр талын дунд энэ хот оршдог бөгөөд цамхгуудын орой дээрээс алсад босох тоос шорооноос дайсан ойртож буйг мэдэх боломжтой байж. Ингэснээр хот цэргүүдээ хамгаалалтанд бэлдэж амждаг байж. Бунхан нь тулааны үеэр амь үрэгдсэн хатных байв. Орой дээр нь овоо байсан ба бид бүгд овоог гурван удаа тойрсон. Бунханы эргэн тойронд сонирхол татмаар, нэлээд хэдэн ногоон өнгийн чулуунууд мөн хэд хэдэн жижиг овоо байсан. Бүгдийнх нь орой дээр морины гавлын яс байв. Би Арпадын үеийн хаадыг дүрсэлсэн түлхүүрийн оосороо хатны бунхан дээрх овооны шон дээр уясан.

Бид талын шороон замаар явалгүй төв засмал замаар явж, зам зуур модоор барьсан уламжлалт хоолны газар оров. Энд зөвхөн монгол хоолоор үйлчилдэг бөгөөд голын өрөөнөөс салбарласан хэд хэдэн өрөө байна. Өрөөнүүдийн ханыг дагуулан буйдангуудыг дугуй хэлбэртэй байрлуулсан байлаа. Аян замын хүмүүс энд нуруугаа амраагаад цоо шинэ эрч хүчээр аяллаа үргэлжлүүлнэ. Үүний тулд нэмэлт төлбөр төлөх шаардлагагүй. Мөн тэнд хонуутаар амрах хүсэлтэй хүмүүс дээд давхарт өрөө захиалж болно. Бид өдий хүртэл үргэлж цоо шинэ XXI зууны зоогийн газар-хүлээн авалтын танхимд хооллож, цай кофе уухаар зогсдог байсан. Эдгээр шинэ зоогийн газруудад зөвхөн монгол хоол захиалаад зогсохгүй Миклошийн ярьснаар бол “Зеллер”-ийн зутан шөл хүртэл идэх боломжтой бөгөөд махны амт илүү амтагдсан шөл байдаг байна.

Улаанбаатарт орж ирэхэд харанхуй болж байлаа. Салхи дахин ширүүсэв. Хол замд ядарсан болохоор зоогийн газар хамт хооллохгүй, бүгд л гэр гэртээ харихыг хүсч байв.

Хэдхэн хоногийн дотор бид голчлон хээр талын шороон замыг даган давхиж, олон мянган км замыг туулсан. Монгол жолооч нар замаа сайн мэдэж, машинаа үнэхээр чадварлаг жолоодон өдөрт 600 км хүртэл газрыг туулж чадсан. Бид ихэвчлэн өглөө, оройд хооллодог байсан ба заримдаа цүнхэн дэх хоолоо идэж, заримдаа замын хажуугийн зоогийн газар хоолонд ордог байв. Монгол сүүтэй, давстай цай замд явахад үнэхээр сайн. Эрч хүч өгч, эрдэс давсыг нөхөж цангааг сайн тайлдаг. Өмнө нь бид халуун сав



авч явдаг байсан бөгөөд замдаа цайгаа маш хурдан чаначихдаг байсан. Тал хээр нутгийн нүүдэлчдийн хувьд шим тэжээлтэй, авч явахад хялбар, удаан хадгалагддаг идээ ундаа чухал байсан. Жишээ нь, борц.

Маттео Виллани, XIV зуунд Италид тулалдаж байсан (Нодь Лаёшийн довтолгоны үед) унгарчууд борцыг хэрхэн бэлтгэж хүнсэндээ хэрэглэдэг байсан талаар дурдсан байдаг. Бас маш удаан хадгалагддаг, бага зэрэг хүчиллэг амттай ааруул надад таалагдсан.

Хэдийгээр бид 5-р сарын эхний долоо хоногт тэнд очсон ч шөнөдөө ихэвчлэн -8 хэм хүрч, салхи ихтэй байсан. Ийм аялалд гарах хүн бүр дулаан гутал, босоо захтай зузаавтар хүрэм, малгай, бээлий авч явах ёстой. Унгарт ойрхон ой руу явсан ч надад усны дашмаг, хутга, гал асаагч байж л байдаг.
























### АШИГЛАСАН БҮТЭЭЛ:

1. Барта Жолт: “Монголын гал тахих ёс”, Напкут хэвлэлийн газар, Вр., 2016.
2. Бона Иштван: “Хүннү нар ба тэдний агуу хаад”, Корвина, Будапешт, 1993 он.
3. Чөгөр Энিকে: “Тордатурын итгэл үнэмшлийн ертөнц”, Критерион хэвлэлийн газар, Клуб, 1998 он.
4. Диенеш Иштван: “Эзлэн түрэмгийлэгч Унгарчууд”, Корвина хэвлэлийн газар, Будапешт. 1974 он.
5. Миклош Пал: “Тунхуан дахь Буддагийн мянган агуй сүм”, Унгарын Хеликон. Будапешт, 1959 он.
6. Мориц Жигмонд: “Өгүүллэгүүд”, Уран зохиолын ном хэвлэлийн газар, Вр., 1955.
7. Нодь Карой: “Ес дэх төрөлт”, “Бодол”, Будапешт, 1985.
8. Рац Габор: “Монгол дахь аялал”, Минерва, Вр., 1974.
9. Рона-Таш Андраш: “Нүүдэлчдийн мөрөөр”, Гондолат хэвлэлийн газар, Вр., 1961.
10. Ред: Г.Эрэгзэн, С.Чулуун. “Монголын хадны оршуулгын дурсгал” Археологийн хүрээлэн, Улаанбаатар, 2022 он.
11. Ред: Какук Жуза: “Чулуунд мөнх сийлсэн”, Европ хэвлэлийн газар. 1985 он.
12. Ред: Сельмеци Ковач-Атила Шацвай Эва: “Унгарын ард түмний уламжлалт соёл”, Угсаатны зүйн музей. Будапешт, 1997.





**Түүхч-Археологич, Тулааны урлагийн багш, доктор Хидан Чобо Ласло өдгөө Кароли Гашпарын нэрэмжит Реформатүш Их Сургуулийн доцент, “Алтан сэлэм” түүхэн сэлэмний урлагийн сургуулийг үндэслэгч юм.**

Түүний судалгааны үндсэн чиглэлүүд: Тал нутгийн нүүдэлчдийн хувцас ба зэвсгийн түүх, нүүдэлчдийн дайтах, байлдах арга барил, туршилтын археологи.

Доктор Хидан Чобо Ласло кинонд түүхэн тулааны шинжээчээр ажилладаг. Унгарын Зэвсэгт хүчний бэлтгэл офицер. Тэрээр 1993 онд дундад зууны үеийн монголчуудын аян дайны сэдвээр диссертаци бичиж, түүнээс хойш Монголын цэргийн түүх, археологийн чиглэлээр ажиллаж байна. 2013 онд түүний дээд боловсролын салбарт оруулсан хувь нэмэр, зэр зэвсгийн олон талт түүхэн судалгааг үнэлж, Унгар улсын төрийн дээд шагнал “Хүлэг баатарын гавьяаны загалмай” одонгоор шагнасан. 2023 онд Унгар, Монголын Хүннү судлалын хамтарсан судалгаанд оролцсон хоёр жилийн нь хөдөлмөрийг үнэлж, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнгээс түүнд Хүндэт өргөмжлөл гардуулсан.

#### **Голлох бүтээлүүд нь:**

- Др.Хидан Чобо Ласло: “Унгарын эртний зэвсгүүд нь зөвхөн уламжлалаа хадгалагч хүмүүст зориулагдаагүй” Зриний хэвлэлийн газар, Будапешт 2018 он.
- Хидан Чобо Ласло: “Унгарын гар дахь зэвсгүүд” Юникуш хэвлэл, Будапешт, 2015 он.
- Хидан Чобо-Селлюши Габор: “Тапиоселегийн Блашкович Музейн зэр зэвсэг болон морины хэрэгслийн цуглуулга” Сентендре: Пешт мужийн музейн захиргаа, 2008 он.
- Ласло Ривис –Чилло Шиклуди - Чобо Хидан–Михай Бенкү: “Between East and West” Budapest, 1996.
- Хидан Чобо Ласло: “Дайтах урлаг - Хүний хүчин зүйл” Будапешт, Юникуш хэвлэл, 2020 он.
- Хидан Чобо Ласло, Январи Зултан: “Хатан зоригтнууд” Будапешт, Карпатия хэвлэл Кбрбtia, 2020.

2022 онд Улаанбаатар хотноо Чингис хааны 860 дахь Олон улсын бага хуралд тал нутгийн нүүдэлчин ард түмний хуяг, дуулга, төмөр хувцас хэрэглэлийн тухай лекц уншиж, мөн онд Монгол улсад анх удаа зохион байгуулагдсан “Унгарын соёлын өдрүүд” арга хэмжээнд Унгарын эртний түүхэн баатрын хувцастай үзүүлбэр үзүүлсэн. Унгар улсад сэлэм, байлдааны сүх болон жадтай үзүүлбэрийг долоо хоног бүр зохион байгуулдаг. Тэрээр лекцүүд болон үзүүлбэрүүддээ Унгарын ард түмний дорнын тал нутгийн угшил гарал, өнөөгийн тал нутгийн ард түмнүүдтэй хамаарах оюун санааны холбоог байнга онцлон тэмдэглэдэг. Түүний Монгол-Унгарын найрамдлын талаар юу бодож байгааг “Монголчуудын нууц товчоо” номны “Бид ам хэлээрээ ярьдаг ч, зүрх сэтгэлээрээ бие биенээ ойлгодог” хэмээх ишлэлээр хамгийн сайн илэрхийлж болох юм.

